



СЭЛЭНГЭ АЙМАГ
САНТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 04 сарын 29. өдөр

Дугаар 1155

Цагаантолгой

Г

Шүлхий өвчинөөс сэргийлэх яаралтай
дархлаажуулалтын ажлыг зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.11 дүгээр заалт, “Мал амьтны эрүүл мэндийн тухай” хуулийн 6 дугаар зүйлийн 6.4, 9 дүгээр зүйлийн 9.1, 9.4-9.8, Улсын онцгой комиссын 2022 оны 02 дугаар тогтоол, Мал эмнэлгийн өрөнхий газрын даргын 2022 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн A/77 тоот тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын нутаг дэвсгэрийн хэмжээнд мал амьтны гоц халдварт шүлхий өвчинөөс урьдчилан сэргийлэх яаралтай дархлаажуулалтын 2022 оны 4 дүгээр сарын 18-ны өдрөөс эхлэн 20 хоногийн хугацаанд ажлыг зохион байгуулсугай.

2. Дархлаажуулалтын арга хэмжээг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай

Ажлын хэсгийн ахлагч - А.Одхүү-(Засаг даргын Тамгын газрын дарга)

Гишигдэд-Г.Анхбаяр-(МЭТ-ийн тархвар зүйч)

Л.Сэлэнгэсайхан -(Ивэн 1-р багийн Засаг дарга)

Б.Золбаяр -(Хушаат 2-р багийн Засаг дарга)

О.Лхагвасүрэн- (Сантбаянхайрхан МЭҮН-н Захирал)

Ө.Ганбаатар -(Бошгын булаг ХХК-ны Захирал)

3. Ажлын хэсэгт ДААЛГАХ нь:

а/ Мал, амьтны гоц халдварт шүлхий өвчинөөс урьдчилан сэргийлэх, дархлаажуулах үйл ажиллагаанд ААНБ, малчин, мал бүхий өрхийн 2021 оны жилийн эцсийн мал тооллогод хамрагдсан болон сумын нутаг дэвсгэр дээр байгаа үхэр, гахайг бүрэн хамруулах

б/Дархлаажуулалтын явцад мал амьтны шилжилт хөдөлгөөнд тавиххяналтыг сайжруулах

в/ Дархлаажуулах ажлаас малаа хоцроосон, зайлсхийсэн аж ахуй нэгж байгууллага, иргэд, хариуцлагагүй хандсан албан тушаалтанд хуулийн дагуу арга хэмжээ авч хариуцлага тооцох

г/ Дархлаажуулалтын товлосон хугацаанд мал, амьтныг бэлэн байлгаж бэхлэх, мал эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх нөхцөл бүрдүүлж, малын эмчийн аюулгүй байдлыг бүрэн хангах

д/ Энэ арга хэмжээний зорилго ач холбогдол хор хохирлын талаар ухуулга сурталчилгаа зохион байгуулах

е/ Арга хэмжээг товлолт хугацаанд чанартай хийж, урьдчилан сэргийлэх арга хэмжээний тайланг гарган санхүүжилтийн материалыг бүрдүүлэн сумын Засаг даргаар батлуулж аймгийн Мал эмнэлгийн газарт хүргүүлэх

4. Энэхүү захирамжийн биелэлтэд хяналт ажиллахыг сумын Засаг даргын орлогч (Б.Мөнх-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.



С.ШИЖИРБААТАР

Боловсруулсан: Г.Анисадр.
Хийнсан: Г.Анисадр.
Хувь: 2.
Огноо: 2022.04.29.